



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/120

Булган сум

**Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах  
эрх олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 2021 оны 124 дүгээр тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108-р тушаалаар батлагдсан "Зураг төслийн жишиг үнийн дүрэм" БД 81-16-20, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV хуралдааны XIV/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган сумын 4 дүгээр багийн гудамж зам талбайн гэрэлтүүлгийн зураг төсөв боловсруулах ажлыг 6,000,000 (зургаан сая) төгрөгөөр "Жоди прожект" ХХК-тай гэрээ шууд байгуулах эрхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Гэрээнд заагдсан ажлыг тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэн хүлээлгэн өгөхийг "Жоди прожект" ХХК (Э.Мөнхтулга)-д үүрэг болгосугай.

3.Булган сумын 4 дүгээр багийн гудамж зам талбайн гэрэлтүүлгийн зураг төсөв боловсруулах ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, хүлээн авахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

4.Дээрх ажлын санхүүжилтийг тухайн арга хэмжээний батлагдсан төсвөөс гэрээнд заасан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

